



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №3

2020 оны 01 дүгээр сарын 13-17

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 4 яаралтай дуудлагыг хүлээн авсан. Эдгээрийн 1(25%) хачигт халдвар, 1(25%) галзуугийн эрсдэлд өртсөн, 2(50%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол:

- 2020 оны 01 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд зоонозын шалтгаант хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй байна.

1.1 Мэрэгч амьтны дуудлага

Нийслэлийн СХД-ийн “Эмээлт” АТШН товчооноос (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийн тээврийн хэрэгслэл) ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага) 5 удаагийн дуудлагад үйлчилж, эрсдэлийг тодорхойлохоор лабораторийн шинжилгээ хийж байна. Он гарсаар нийслэлийн 2 дүүргийн хэмжээнд нийт 9 удаагийн амьтны дуудлагад үйлчилсэн.

ХОЁР. ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ


Монгол улсад:

- Мал, амьтны өвчлөл бүртгэгдээгүй.

Олон улсад:

Эбола вируст халдвар:

2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад эбола вируст халдварын сэжигтэй 3392 тохиолдол бүртгэгдсэнээс 2235(66%) нь нас барсан байна. Нийт тохиолдлын 1903(56%) нь эмэгтэйчүүд, 956(28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзлэж байна.



Эх сурвалж: ДЭМБ

Шинэ коронавирусийн халдвар:

БНХАУ-ын Хубэй мужийн Үхань хотод шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа өвчин бүртгэгдсэн талаар өнгөрсөн долоо хоногт мэдээлсэн. Шинэ төрлийн Коронавирус нь вирусийн том омог бөгөөд зарим нь хөнгөн хэлбэрийн өвчлөл үүсгэдэг бол зарим төрлийн вирус нь хүнд хэлбэрийн өвчлөл үүсгэдэг байна. Мөн лабораторийн шинжилгээний хариугаар SARS-CoV, MERS-CoV, томуу, шувууны томуу, Аденовирус болон амьсгалын замын халдварын үүсгэгчдийг үгүйсгэсэн байна.

ДЭМБ-ын 2020 оны 01 дүгээр сарын 11,12-ны мэдээлснээр Үхань хотод халдвар авсан 41 тохиолдоос 7 өвчтөний биеийн байдал хүнд байна. Одоогийн байдлаар шинэ төрлийн коронавирус Үхань хотоос өөр газар бүртгэгдээгүй байна.

Эх сурвалж: ДЭМБ

Шинэ коронавирусийн халдвар: (Тайланд улс)

Тайланд улсад шинэ коронавирусийн халдварын 1 тохиолдол бүртгэгдсэн талаар нийтлэгдсэн байна. 61 настай, эмэгтэй. Түүнд халуурах, хоолой өвдөх, толгой өвдөх шинж тэмдэг илэрсэн байна. 2020 оны 01 дүгээр сарын 8-ны өдөр Хубэй мужийн Үхань хотоос гэр бүлийн хамт Тайланд руу шууд нислэгээр явсан байна. Тандалт судалгаа үргэлжилж байна.

Эх сурвалж outbreaknewstoday.com

Шинэ коронавирусийн халдвар:

БНХАУ-ын Хубэй мужийн Үхань хотын эрүүл мэнд, эрүүл мэндийн хорооноос 2020 оны 01 дүгээр сарын 15-нд шинэ коронавирусийн халдвар хүнээс хүнд дамжсан тохиолдол бүртгэгдээгүй талаар мэдээлсэн байна. Клиник болон тандалт судалгааны мэдээллийг нэгтгэж, цаашдын судалгаа хийгдэж байна. Одоогийн байдлаар шинэ коронавирусийн халдвараар оношлогдсон 41 тохиолдол бүртгэгдсэнээс гэр бүлийн эхнэр, нөхөр хоёрт илэрсэн байна. Нөхөр нь далайн хүнсний бүтээгдэхүүн зардаг захад ажилладаг байсан нь халдвар авсан байх магадлалтай байна.

Шинэ коронавирусийн халдварын эмнэлгийн ажиглалтын хугацааг 14 хоног тогтоосон. Тухайлбал ажиглалтын хугацаанд ойр дотны хүмүүст нь халуурах, ханиалгах зэрэг хэвийн бус шинж тэмдэг илэрсэн тохиолдолд цаг алдалгүй эрүүл мэндийн байгууллагад хандах шаардлагатайг зөвлөсөн. БНХАУ-ын Хубэй мужийн Үхань хот нь дотоодын болон олон улсын тээврийн чухал төв юм. Мөн тус далайн хүнсний бүтээгдэхүүн зардаг захыг түр хугацаагаар хаасан байна. Хонг Конгийн засгийн газар орон нутгийн урьдчилан сэргийлэх, хянах, халдварт өвчний нөхцөл байдлыг шалгахгаар Үхань хотод мэргэжилтнүүдээ илгээжээ. БНХАУ-д гарсан энэ удаагийн уушгины хатгалгааны вирус нь урьд өмнө мэдэгдэж байгаагүй төрөл бөгөөд SARS ба MERS вирусстэй нэг бүлгээс гаралтай гэж мэдэгдсэн байна. Энэ нь том хэмжээний халдварын хямралыг давтах уу үгүй юу гэдэгт санаа зовж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тархалт хараахан тархаагүй байгааг мэдэгдсэн байна.

Эх сурвалж: <https://www.dwnnews.com>

Шинэ коронавирусийн халдвар: (Япон улс)

Японд улсад шинэ коронавирусийн халдварын батлагдсан 1 тохиолдол бүртгэгдсэн талаар мэдээлсэн байна. 30 настай, эрэгтэй. БНХАУ-ын Үхань хотод аялалаар явсан өгүүлэмжтэй. Тэрбээр Токио хотын ойролцоох Канагава мужид амьдардаг. 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр эмнэлэгт хэвтсэн. Лабораторийн шинжилгээгээр шинэ коронавирус болох нь батлагдсан байна.

Шинэ коронавирүсийн халдвар:

БНХАУ-ын Хубэй мужийн Үхань хотод шинэ коронавирүсийн халдвараар 1 хүн нас барсан байна. БНХАУ-ын Үхань хотод шинэ коронавирүсийн халдварын дэгдэлт өргөн тархсан байна. Үхань хотын Эрүүл мэнд, эмнэлгийн хорооны 2020 оны 01 дүгээр сарын 16-ны 23:55 цагт мэдээлснээр 5 өвчтөн эдгэрч эмнэлгээс гарч, шинээр 1 хүн нас барсан. Уг хүн 69 настай. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр халдвар авч өвчилсөн байна.


2020 оны 01 дүгээр сарын 04-нд өвчний явц хүндэрч Үхань хотын Жиньпин эмнэлэгт шилжүүлсэн. Өвчтөн эмнэлэгт хэвтэх үед хүнд хэлбэрийн миокардит (миокардийн фермент хэвийн хэмжээнээс 20 дахин нэмэгдсэн, электрокардиограм хэвийн бус) бөөрний үйл ажиллагааны хэвийн бус бусад эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны сулрал байсан. Түүгээр ч барахгүй өвчтөний цээжний СТ нь уушгины фиброз, гялтангийн шүүдэст үрэвсэлтэй (сүрьеэ ба гялтангийн сүрьеэ) байсан ба түүнийг аврах ажиллагаа үр дүнгүй байснаас 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 00:45 цагт нас барсан байна.

Одоогийн байдлаар Үхань хотод нийт коронавирүсийн халдвартай 41 тохиолдол бүртгэгдэж, 12 хүн эдгэрч эмнэлгээс гарсан, 5 өвчтөн хүнд хэлбэртэй, 2 хүн нас барсан. Бусад өвчтөнүүдийн биеийн байдал хэвийн байгаа ба өвчтөнүүдийг Үхань дахь тусгай эмнэлгийн байгууллагад тусгаарлаж байгаа юм байна.

Нийт 763 ойрын хавьталтай хүмүүсийг бүртгэж, 644 хүнд эрүүл мэндийн үзлэг хийсэн, 119 хүний эрүүл мэндийн үзлэг явагдаж байгаа бөгөөд ойр дотны хүмүүсийн дунд өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна. Хүнээс хүнд дамжих эрсдэл бага байна. Цаашид судалгааг эмнэлзүйн болон эпидемиологийн мэдээлэлтэй хослуулан явуулж байна.

Эх сурвалж: www.dwnnews.com**Хонины цэцэг өвчин:**


ОХУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2020 оны 01 дүгээр сарын 03-нд Псковские мужийн аж ахуйд хонины цэцэг өвчний дэгдэлт бүртгэгдсэн. Нийт 14 хонь өвчилж, 8 хонийг устгасан байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Шувууны томуу өвчин:

БНХАУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 12 дугаар сарын 28-нд Юньлин мужийн фермд шувууны томуугийн H5N2 вируст халдварын дэгдэлт бүртгэгдсэн байна. Нийт 2432 шувуу өвчилж үхэн, 20979 шувууг устгасан байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Хэл хөхрөх өвчин:

Белги улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 12 дүгээр сарын 19-нд Антверпент дүүрэгт хэл хөхрөх өвчин бүртгэгдэж, 1 үхэр өвчилсөн байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.

Эх сурвалж: ДМАЭМБ

Мал, амьтны боом өвчин:

2020 оны 01 дүгээр сарын 16-нд Зимбабве улсын Масвинго мужид мал, амьтны боом өвчний дэгдэлт бүртгэгдсэн талаар нийтэлсэн байна. Тус мужийн Мал, амьтны мэргэжилтэн Эрнест Дзимвайша хэлэхдээ мал, амьтны боом өвчний дэгдэлтэнд нийт 46 үхэр өвчилсөн болох нь батлагдсан. Түүнчлэн Бикита дүүрэгт 37 хүн, Гуту дүүрэгт 27 хүн халдвартай үхрийн мах хэрэглэсний улмаас боом өвчнөөр өвчилсөн. Бид Гуту дүүрэгт 14000 үхэрт боомын вакцинжуулалт хийгээд байна.

Эх сурвалж: www.zbcnews.co.zw

ЗӨСҮТ, Шуурхай удирдлагын нэгж

nczd.eop@gmail.com

eop@nczd.gov.mn